

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН СТАНДАРТ

М. Мөнхбат¹

Гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын эрх зүйн үндэслэл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах талаарх эрх зүйн үндсийг тодорхойлсон цөөнгүй олон улсын гэрээнд Монгол улс нэгдэн орсон байна. Эдгээр олон улсын гэрээгээр ихэвчлэн гэмт хэргийн гэрч болон хохирогчийг хамгаалах зохих арга хэмжээ авч байх үүргийг гишүүн улс хүлээсэн байдаг.

Тухайлбал, 2000 оны 11 дүгээр сарын 2-нд Монгол улсын нэгдэж орсон НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг 1984 оны конвенцийн 13 дугаар зүйлд гэрээнд оролцогч аливаа улс *“Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна”*, Монгол улс 2002 оны 10 дугаар сарын 11-нд нэгдэн орсон Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцид оруулах нэмэлт протоколын² 8 дугаар зүйлд оролцогч улсууд *“...хохирогч болсон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг эрүүгийн шүүн таслах бүх ажиллагааны үед ... хамгаалах талаар зохих арга хэмжээ авна”* гэх зэргээр үүрэг хүлээдэг байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн A/RES/40/43 тогтоолоор баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тунхаглал³”-ын 6 дугаар заалтад *“...гэмт хэргийн хохирогчдын аюулгүй байдлын нэн тохиромжтой нөхцлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах...”* үүргийг тогтоожээ.

Мөн Авлигын эсрэг НҮБ-ын конвенц⁴-ийн 32 дугаар зүйлийн 1-д, Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенц⁵-ийн 3 дугаар зүйлийн 1-д, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм⁶-ийн 68 дугаар зүйлийн 1-д, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн 25 дугаар зүйлийн 1-д хохирогч, гэрчүүдийг **хамгаалахын** тулд шаардлагатай бүх арга хэмжээг авах үүргийг тус тус заажээ.

¹ МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхмийн ахлах багш, докторант

² НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталж, 2002 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон

³ Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power

⁴ “Төрийн мэдээлэл” эмхтгэл. 2005 он. №43 (424). 855-888 дахь тал

⁵ “Төрийн мэдээлэл” эмхтгэл. Тусгай дугаар. IV боть. 904-910 дахь тал.

⁶ “Төрийн мэдээлэл” эмхтгэл. Тусгай дугаар. II боть. 2005. 319-405 дахь тал

Гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын эрх зүйн жишиг

Шударга шүүх, шударга шүүх ажиллагааны үндэс, эрх зүйн баталгааг тодорхойлох стандартыг боловсруулах асуудал нь олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарлыг татсан чухал асуудлын нэг. Тэр дундаа, аюулгүй байдал нь халдлага, заналхийлэлд өртөж буй эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг хамгаалах үр дүнтэй механизмыг бүрдүүлэх асуудалд дэлхийн олон улс анхаарч байна. Энэ нь зохион байгуулалттай гэмт хэрэг улам боловсронгуй болж буй болон шудрага шүүх ажиллагаа явуулахад саад учруулах явдал газар авч буйтай нь холбоотой байна. Зохион байгуулалттай гэмт явдлын халдлагад шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнаас гадна гэрч, хохирогчид өртдөг байна.

Хүний эрхийн стандартыг тогтоосон баримт бичгийн үндэс нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын гол үзэл санааг дараагийн түвшинд хөгжүүлсэн баримт бичиг бол 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн пакт” юм. Энэ баримт бичиг нь гэрч, хохирогч болон шүүх ажиллагааны бусад оролцогчдыг хамгаалах олон улсын стандартыг өндөр түвшинд тодорхойлж өгчээ. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн пактын 14 дүгээр зүйлд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд олгогдох баталгааг тогтоож өгсөн байдаг. Энэ зүйлд “хувийн амьдралын эрх ашгийн үүднээс ... шүүх өөрийн санаачилгаар ... шүүх ажиллагаанд бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт зайлшгүй гэж тогтоосон хэмжээгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг оролцуулахгүй байж болно”, өөрөөр хэлбэл гэрч, хохирогчийн аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулж болно гэсэн үг.

Энэхүү Пактаар тогтоосон стандарт болон эдгээр стандартыг хэрэгжүүлэх журам нь гишүүн улсуудад заавал биелүүлэх хууль зүйн хүчин чадалтай. Пактын 2 дугаар зүйлийн 3-ын дагуу гишүүн улс бүр дараах үүрэгтэй:

(а) энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;

(b) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх;

(c) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах.

Энэхүү баримт бичиг нь ерөнхий боловч гэрч, хохирогчийн хувьд эдгээр заалт нь суурь ач холбогдолтой юм.

Мөн олон улсын стандарт боловсруулах НҮБ-ын эрх бүхий байгууллагуудаас шүүхийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны стандартыг боловсруулан батлуулсан байдаг. Учир нь гэрч, хохирогчийг хамгаалах, тэдгээрийн арга хэмжээний үр нөлөө, хэрэгжилт нь шүүгч, прокурор, мөрдөн байцаагч болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогчдын мэргэжлийн ур чадвар, ёс зүй зэргээс ихээхэн хамаардаг. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагын үйл ажиллагааны стандарт болсон хэд хэдэн баримт бичиг байдаг. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1980 оны 12 дугаар сарын

15-ны өдөр 35/171 дүгээр тогтоолоор баталсан “Каракассын тунхаглал”-д шүүх ажиллагааг шуурхай, шударга явуулах чадамжтайгаас гадна оролцогчдын аюулгүй байдлыг хангах болон эрх, эрх чөлөөг нь хамгаалах чадамжтай шүүхээр явуулах зарчимд эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоо үндэслэгдэх ёстойг заасан байдаг бол 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодекс”, “Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтны зан үйлийн кодексыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд баримтлах удирдлага болгох зарчим”-аар хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс хүний эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэн дээдлэх, хамгаалах, зохистой харилцааны наад захын жишгийг тогтоож өгсөн байдаг. Эдгээр хэм хэмжээ нь мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/32 тогтоолоор баталсан “Шүүхийн байгууллагын бие даасан байдлын үндсэн зарчим”, НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба гэмт хэрэгтэнтэй харьцах асуудлаарх Конгрессын VIII чуулганаар баталсан “Хуульчийн үүрэг гүйцэтгэхтэй холбоотой үндсэн зарчим” гэх зэрэг баримт бичигт тусгагдсан байдаг байна.

Харин 1985 оноос гэрч, хохирогчийг хамгаалах асуудалд тусгайлан анхаарлаа хандуулж наад захын жишгийг тогтоож өгсөн байна. Энэ нь Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 тогтоолоор батлагдан гарсан Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал юм.

Энэ баримт бичгээр хохирогчийг “гэмт хэргийн золиос бологч” гэх өргөн утгаар тайлбарласан бөгөөд “гэмт хэргийн золиос бологч” буюу “хохирогч” гэдгийг үндэсний эрүүгийн хууль тогтоомжоор гэмт үйлдэл, эс үйлдлээс бие махбодид гэмтэл, оюун санааны хохирол, сэтгэл санааны зовиур, материаллаг гэм хор учирсан, эсхүл түүний үндсэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ноцтой хэмжээнд халдлагад өртсөн аливаа этгээдийг ойлгоно. “Хохирогч” гэдгийг Тунхаглалын дагуу мөн өргөн утгаар ойлгох бас нэг үндэслэл нь гэмт этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, саатуулагдсан, баривчлагдсан, шүүх хянан шийдвэрлэсэн эсэхээс болон хохирогч болон гэмт хэрэгтний хоорондын гэр бүл, хамаатан, садангийн харилцаанаас үл шалтгаалан хохирсон этгээд, түүний ойрын гэр бүлийн гишүүд, халамжид нь байгаа хүмүүс хохирогч байхаар заасан байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч аливаа этгээд хэрэв түүнд хууль бусаар нөлөөлж байвал “хохирогч”-д тооцогдоно гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, гэрч, хохирогч гэсэн нэр томъёог нэгтгэн Тунхаглалын “хохирогч” гэдэгт багтаан ойлгоно.

Тунхаглалаар гэмт хэргийн хохирогчдод чухал болох хэд хэдэн ач холбогдолтой зарчмыг тогтоосон байдаг. Эдгээрээс чухлыг нь дурдвал:

- гэмт хэргийн хохирогчтой шударгаар харьцах,
- гэмт хэргийн хохирогчдод хууль ёсны болон захиргааны хамгаалалтын механизмын хүртээмжтэй байдлыг хангах,
- айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс хамгаалах,
- шаардлагатай мэдээллээр хангагдах эрхээр хангах,
- нөхөн олговор, нийгмийн халамжид хамруулах зэрэг зарчим байна.

Гэмт хэргийн хохирогчтой шударгаар харьцах нь гол зарчмын нэг бөгөөд энэ нь шударга шүүх, шүүх ажиллагааны үндэс болдог. Тунхаглалын дагуу гэрч, хохирогчтой харьцахдаа нэр хүндийг нь хүндэтгэн, өрөвдөх сэтгэлээр харьцахыг шаарддаг. Шүүх болон захиргааны бүх

механизм нь хохирогчдод хүртээмжтэй, шуурхай байх бөгөөд зохих хэмжээнд тэдгээрийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байх ёстой. Тэдгээрийн эрх ашиг хөндөгдөж байгаа бол өөрийн байр суурь, хүсэлтээ гаргаж шүүхийн аль ч шатанд илэрхийлэх эрхтэй.

Харин Тунхаглалын 6.d-д айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс хамгаалагдах зарчмыг “хохирогчийн таагүй байдлыг доод хэмжээнд хүргэх, амь насыг нь шаардлагатай тохиолдол бүрт хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, гэрчийн аюулгүй байдлыг хангах болон айлган сүрдүүлэх, өшөө авалт зэргээс хамгаалах арга хэмжээг авахыг” зохистойгоор тайлбарлажээ.

Хохирогч гомдлоо хэрхэн барагдуулах, хэрхэн хамгаалуулах талаар ямар эрхтэйгээ мэдэх боломжтой байхаас гадна хууль сахиулах байгууллагын ажилтан түүнд шүүх ажиллагаанд оролцох шаардлага, ямар үүрэгтэй оролцох талаар таниулах үүрэгтэй байна. Үүнээс гадна шүүхийн урьдчилсан ажиллагааны явц болон шүүх ажиллагааны хугацаа, дараалал, явц болон үр дүнгийн талаар мэдээллээр хангах ёстой. Түүнчлэн шүүхийн болон захиргааны журмаар хохирлоо барагдуулах тохиолдолд түүний бүх эрхийг танилцуулах ба эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар мэдээлэхээс гадна тэдгээрийг ашиглах боломжоор хангах ёстой.

Энэ Тунхаглалд хохирогчийн өмнө төр өөрийн үүргийг хангахын тулд тусгай зорилтын сан байгуулах, бэхжүүлэх ёстойг заасан байна. Хэрэв сан нь хохирлын хэмжээг бүрэн барагдуулах боломжгүй бол энэ зориулалтаар нэмэлт сан байгуулах боломжийг ашиглах ёстой байна. Хохирол барагдуулах албан, албан бус механизм нь хялбар, хэрэгжих боломжтой байх ёстойгоос гадна шударга, зохих судалгаанд үндэслэгдсэн, өртөг, чирэгдэл багатай байх ёстой байдаг. Хохирогчийн хохирлыг барагдуулахаас гадна түүний гэр бүлийн гишүүн, халамжид буй хүмүүс нь нөхөн төлбөр авах эрхээр хангагдах ёстой байна.

Энэхүү баримт бичиг нь шүүх, хуулийн байгууллагын ажилтанд хохирогчийн асуудлаарх зохих гарын авлага болохоос гадна энэ салбарын хууль тогтоомжийн үндэс болж гэрч, хохирогчийг хамгаалах механизмыг бүрдүүлэхэд ач холбогдол бүхий үүрэг гүйцэтгэх стандарт юм. Энэхүү баримт бичгээр тогтоосон стандартын дагуу өнөөдөр хохирогчийг хамгаалах асуудлаараа аль улс ямар түвшинд байгааг тодорхойлдог болсон байна.

1989 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн Эдийн засаг, нийгмийн Зөвлөлийн 1989/57 тогтоолоор “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаархи хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж” баталсан байдаг. НҮБ-ын гишүүн улсуудад хандсан энэхүү баримт бичгийн 2 дугаар заалтад “а) үндсэн хууль болон дотоодын практик (үүнийг эрх зүйн бүлээс хамаарна гэж ойлгох)-т нийцүүлэн Тунхаглалын зүйл, заалтыг үндэсний шүүх эрх мэдлийн тогтолцоонд батлах, хэрэгжүүлэх ... d) гэмт хэрэгтэй холбоотой аливаа эрүүгийн байцаан шийтгэх болон бусад ажиллагааны явцад болон хойно гүтгэлэг, айлган сүрдүүлэх байдлаас хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулах” зэрэг арга хэлбэрээр тунхаглалыг хэрэгжүүлэхийг зөвлөмжилсөн байна. Харин НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас тухайн зөвлөмжийг дэмжин сайшааж 1989 оны 12 дугаар сарын 15-ны 44/162 тогтоолоор гишүүн улсуудад “шүүн шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах талаар НҮБ-ын хэм хэмжээ, стандартыг хэрэгжүүлэх стратегийг боловсруулахдаа” энэхүү зөвлөмжийг харгалзан тооцохыг санал болгосон байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны салбар дахь ХХI зууны олон улсын хамтын ажиллагаа” сэдвээр НҮБ-ын VIII Конгресс 1990 онд Гавана хотод хуралдахдаа гэрч, хохирогчийн асуудалд онцгой анхаарч “Хөгжлийн хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны салбар дахь олон улсын хамтын ажиллагаанд баримтлах Зөвлөмж” гэх чуулганы үр дүнгийн баримт бичгийн 18.с-д нийтээр анхаарал хандуулж, цаашид боловсруулах асуудлын нэг нь гэрч, хохирогчийн “зохистой хамгаалалтаар” хангах асуудал гэдгийг тэмдэглээд улс болгон гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн зарчмуудыг боловсруулахыг үүрэг болгожээ. Мөн тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах шаардлагад чуулган анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал, “Олон улсын терроризмтай тэмцэх арга хэмжээ” гэх тогтоолын “L. Хохирогчийг хамгаалах” хэсгийн 23-т “Улс бүр терроризмын хохирогчийг хамгаалах механизмыг бий болгох, холбогдох хууль тогтоомж гаргах, тэдгээрт туслалцаа үзүүлэх хангалттай хөрөнгийг гаргах шаардлагатай” гэсэн бол гэрчийн хувьд мөн “M. Гэрчийг хамгаалах” хэсгийн 25-д “Улс бүр террорист ажиллагааны гэрчийг үр дүнтэй хамгаалахад чиглэсэн арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай” гэж үзжээ.

Харин 1990 оны “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдийн талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсруулсан эрүүгийн байцаан шийтгэх тогтолцооны ажилтнуудад зориулсан зааварчилгаа”-ны “B.Хохирогч ба эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоо” гэх хэсгийн 35-д “хэрэв гэмт этгээдийн зүгээс сүрдүүлсний улсаас хохирогч нь айж, эмээж байгаа бол цагдаа болон бусад байгууллагаас тухайн хохирогчийг хамгаалах, түүнийг дэмжих бүх арга хэмжээг (тухайлбал, цагдаагийн хамгаалалт, оршин суух газрыг нь өөрчлөх) авах ёстой ... Ийм арга хэмжээ авч, энэ талаараа хохирогчдод мэдэгдэх нь чухал болно”, мөн 55-д “хэрэв хохирогч нь гэрчийн мэдүүлэг өгөхөөсөө айж, эмээж байгаа бол ... шууд видео дүрсээр, эсхүл видео хальсанд бичсэн гэрчийн мэдүүлгийг ашиглахыг зарим хууль тогтоомжоороо зөвшөөрсөн байх...” гэсэн стандартыг тогтоож өгнө.

1991 оны НҮБ-ын ЕА-ийн 46/152 тогтоолоор “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны салбар дахь НҮБ-ын хөтөлбөр”-ийг баталсан ба энэ баримт бичгээр НҮБ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдтэй харьцах талаарх Конгресс болон НҮБ-ын бусад институтуудын үйл ажиллагааг зангидаж өгсөн ба гэмт хэргийн хохирогчийн эрхийг хамгаалах шаардлагыг дахин тэмдэглэсэн.

НҮБ-ын уриа дор явагдсан “Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” талаар Суздалийн олон улсын бага хурал (1991 он), “Эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоонд хүчирхийллийн эрсдэлийг багасгах” талаарх шинжээчдийн тусгай багийн Чикагогийн бага хурал (1993 он)-аар гэрчийн оршин суух газрыг өөрчлөх замаар аюулгүй байдлыг хангах асуудлын агуулга, хэлбэрийг хөндөж анхан шатны болон цогц хамгаалалтын арга хэмжээний шаардлагыг тодорхойлсон байна. Мөн Неапольд 1994 онд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг” асуудлаар зохион байгуулсан олон улсын бага хурлаас гэрч, хохирогчийг хамгаалах “стратегийн” арга хэмжээг авах шаардлагыг хүлээн зөвшөөрч эдгээр арга хэмжээ нь гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд улс орнуудын бодлогын салшгүй хэсэг болох ёстойг, мөн гэрч, хохирогчийг хамгаалах тусгай хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхийг тэмдэглэсэн байна (17, 42 дахь заалт). Энэ хурлын баримт бичиг нь зөвлөмж хэлбэрээр НҮБ-ын ЕА-ийн 49/159 тогтоолоор батлагдсан.

1995 онд Каирт болсон IX Конгрессын баримт бичигт “дахин хохирогч болохоос сэргийлэх арга хэмжээ болгон (хүлээлгийн тусдаа тасалгаа, гэрчийн мэдүүлгийг дүрс бичлэгээр өгөх зэрэг) тусгайлан нөхцөл бүрдүүлэхийг” дэмжсэн байна. Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг анхаарч холбогдох арга хэмжээ авах шаардлага буйг тэмдэглэж тунхагаас тодорхой, бодитой үйл ажиллагаанд шилжих цаг ирсэн гэж үзжээ.

2000 оны НҮБ-ын Конгрессоор баталсан “Гэмт хэрэг ба шүүх эрх мэдэл: XXI зууны хариу” Венийн тунхаглалын 27-д “бид хэрэгцээтэй байгаа үндэсний, бүс нутгийн, олон улсын тэр түвшинд гэмт хэргийн хохирогчийг дэмжих үйл ажиллагааны, тухайлбал зуучлал болон нөхөн олговрын механизмыг бүрдүүлэх төлөвлөгөөг боловсруулан гаргах шийдвэрийг гаргалаа. Бид, 2002 оныг улс гүрнүүдэд өөрийн практикийг дүгнэн үзэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх, хохирогчдын эрхтэй танилцуулах компанит ажлыг зохион байгуулах, мөн түүнчлэн хохирогчдод зориулсан тусгай сан байгуулах, гэрчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг жил болгон тодорхойлж байна” гэжээ.

2010 оны 4 дүгээр сарын 12-19-ны өдрүүдэд Салвадор, Бразилд явагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаарх НҮБ-ын XXII Конгрессын тунхаглалын 5-д “хохирогчийг хамгаалах, тэдгээрт туслалцаа үзүүлэх, дахин хохирогч болохоос хамгаалах үндэсний хууль тогтоомжийг батлан гаргахын чухлыг” тэмдэглэж хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг, мөн зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудалд анхаарахыг уриалсан байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын түгээмэл стандартын зэрэгцээ бүс нутгийн хэмжээнд боловсруулагдсан стандарт хэрэгждэг байна. Энэ нь бүс нутгийн боловч олон улсын хэмжээнд түгээмэл загвар болж, эрх зүйн эх сурвалж болж иржээ. Тухайлбал, Европын зөвлөлийн 1950 онд баталсан “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах Европын конвенц” нь хүний эрх, эрх чөлөөг тунхаглахын зэрэгцээ хамгаалахыг үүрэг болгосон байдаг. Европын Зөвлөл нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчдыг хамгаалах талаарх суурь болсон олон улсын хэд хэдэн баримт бичгийг батлан гаргасан байдаг. 1983 онд “Хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод олгох нөхөн олговрын тухай Европын конвенц”, 1985 оны Эрүүгийн эрх зүйн хүрээнд болон эрүүгийн процесс дахь хохирогчийн байдлын талаарх зөвлөмж, 1987 оны Гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх талаарх зөвлөмж гэх зэрэг баримт бичгийг Европын Зөвлөлөөс батлан гаргасан байна.

Эрүүгийн эрх зүйн хүрээнд болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хохирогчийг хамгаалах талаарх зөвлөмж нь хохирогчийг шүүхэд итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлэхээс гадна түүнийг гэрчийн байр суурьтайгаар шүүх ажиллагаанд оролцох итгэлийг бүрдүүлэхэд чиглэсэн байна. Энэ баримт бичгээр хохирогчид учрах бие махбодь, сэтгэл санаа, эд хөрөнгө болон нийгэмд учруулах хохиролд анхаарлаа хандуулж, энэ талаар хамгаалах бүх арга хэмжээг авахыг улс гүрнүүдэд уриалсан байдаг байна. Энэ арга хэмжээг байцаан шийтгэх ажиллагааны бүх үе шатанд авах ёстой гэжээ.

Мөн түүнчлэн энэхүү баримт бичиг нь хохирогчийг хамгаалах үндсэн зарчмуудыг зөвлөмж болгосон байдгаас дурдвал:

- хохирогчтой харьцах цагдаагийн байгууллагын ажилтны чадварыг сайжруулах сургалт явуулах;

- цагдаагийн байгууллагын ажилтан нь хохирогчийн авч болох эрх зүйн болон бусад туслалцаа, хохирлыг барагдуулах боломж (төрөөс болон гэм буруутай этгээдээс гаргуулах)-ийн талаарх ойлголт мэдээллийг хохирогчид өгөх;
- хохирогчоос мэдүүлэг авахдаа түүний хувийн байдал, нэр хүнд, эрхийг хүндэтгэдэг байх;
- хохирогчийн хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэдэг байх;
- хохирогч этгээд шүүх хурал хэзээ, хаана, яаж явагдах, хохирлыг барагдуулах, нөхөн олговор гаргуулах боломж, байцаан шийтгэх ажиллагааны үр дүнг мэдэх, эрх зүйн туслалцаа болон бусад аргын талаар шүүхээс мэдээлдэг байх;
- үндэсний хууль тогтоомжоор хохирогчид олгох нөхөн олговрыг эрүүгийн санкци хэлбэрээр, эсхүл түүнийг орлох хэлбэрээр, эсхүл эрүүгийн санкцид нэмэгдэл байдлаар тогтоож өгөх;
- хохирогчийн хувийн амьдрал, нэр хүнд хөндөгдөх аливаа баримт, мэдээллийг тараахаас хамгаалагдсан байх;
- гэмт этгээдийн зүгээс хохирогчийг айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс дээд хэмжээгээр хамгаалсан байх.

Дээрх олон улсын баримт бичигт заасан стандарт хэм хэмжээг нэгтгэн үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх талаархи олон улсын хамтын нийгэмлэг дараах жишгийг тогтоосон байна:

- гэрч, хохирогчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах;
- гэрч, хохирогчийг хамгаалах үндсэн зарчмуудыг боловсруулах;
- холбогдох хууль тогтоомж гаргах;
- шүүх ажиллагааг шуурхай, шударга явуулах чадамжтайгаас гадна оролцогчдын аюулгүй байдлыг хангах болон эрх, эрх чөлөөг нь хамгаалах чадамжтай шүүхийг бүрдүүлэх;
- хохирогчтой харьцах шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон оролцогч байгууллагын ажилтны чадварыг сайжруулах, сургалт явуулах;
- хууль сахиулах байгууллагын албан тушаалтны зүгээс гэрч, хохирогчтой харьцах дүрэм;
- хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх;
- гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх хангалттай хөрөнгийг зарцуулдаг механизмыг бий болгох;
- зуучлал болон нөхөн олговрын механизмыг бүрдүүлэх, тусгай зорилтын сан байгуулах, бэхжүүлэх;
- тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах. Тухайлбал, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудал;
- хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг онцгой анхаарах;
- гэмт хэрэгтэй холбоотой аливаа эрүүгийн байцаан шийтгэх болон бусад ажиллагааны явцад болон хойно гүтгэлэг, айлган сүрдүүлэх байдлаас хохирогчийг хамгаалах арга хэмжээг боловсруулах;
- гэрч, хохирогчийн аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах боломж бүрдүүлэх;
- шууд видео дүрсээр, эсхүл видео хальсанд бичсэн гэрчийн мэдүүлгийг ашиглах;

- гэрчийн оршин суух газрыг өөрчлөх замаар аюулгүй байдлыг хангах;
- гэмт хэргийн хохирогчтой шударгаар харьцах;
- гэмт хэргийн хохирогчдод хууль ёсны болон захиргааны хамгаалалтын механизмын хүртээмжтэй байдлыг хангах;
- айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс хамгаалах;
- шаардлагатай мэдээллээр хангагдах эрхээр хангах. Тухайлбал, хохирогчийн авч болох эрх зүйн болон бусад туслалцаа, хохирлыг барагдуулах боломж (төрөөс болон гэм буруутай этгээдээс гаргуулах)-ийн талаарх мэдээлэл; хохирогч этгээд шүүх хурал хэзээ, хаана, яаж явагдах, хохирлыг барагдуулах, нөхөн олговор гаргуулах боломж, байцаан шийтгэх ажиллагааны үр дүнг мэдэх эрх зүйн туслалцаа болон бусад аргын талаар шүүхээс мэдээлдэг байх;
- нөхөн олговор, нийгмийн халамжид хамруулах;
- хохирогчоос мэдүүлэг авахдаа түүний хувийн байдал, нэр хүнд, эрхийг хүндэтгэдэг байх;
- хохирогчийн хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэдэг байх;
- үндэсний хууль тогтоомжоор хохирогчид олгох нөхөн олговрыг эрүүгийн санкци хэлбэрээр, эсхүл түүнийг орлох хэлбэрээр, эсхүл эрүүгийн санкцид нэмэгдэл байдлаар тогтоож өгөх;
- хохирогчийн хувийн амьдрал, нэр хүнд хөндөгдөх аливаа баримт, мэдээллийг тараахаас хамгаалагдсан байх;
- гэмт этгээдийн зүгээс хохирогчийг айлган сүрдүүлэх, өс хонзон авах зэргээс дээд хэмжээгээр хамгаалсан байх.

Олон улсын хамтын нийгэмлэг шударга шүүх ажиллагаа, тэр дундаа эрүүгийн эрх зүйн процесс дахь стандарт болох олон баримт бичгийг боловсруулан баталсан байдаг байдаг. Монгол улс эрүүгийн эрх зүйн тогтолцоогоо өөрөө тодорхойлж, төлөвшүүлэх бүрэн эрхтэй ч хүний эрхийг дээдэлсэн ардчилсан зарчмыг нэгэнтээ сонгосон нь эдгээр олон улсын стандартад үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь нэг талаасаа жам, нөгөө талаасаа зайлшгүй шаардлага юм.